ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/207
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
АРВАН НЭГДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

БИЗКОН АУДИТ

БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ САЛБАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/221/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>Мөрөн сум<br>2022 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг<br>Утас: 99016320 Цахим хаяг:<br>Бизкон аудит ХХК-ийн<br>Аудитор: Д.Эрдэнэжаргал<br>Утас: 99008925 Цахим хаяг:erdenejargald27@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
3. Аудитын тайлан ..... 4
   3.1 Ерөнхий зүйл ..... 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
   3.4 Материаллаг байдал ..... 10
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 13
   3.8 Аудитын гол асуудал ..... 13
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14
4. Аудитын илрүүлэлт ..... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ШХА | Шууд худалдан авалт |
| ИТХТ | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

**СТ-1А**

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,945,336.76** | **71,241,254.28** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **76,295,336.76** | **71,241,254.28** |
| 354 | Хангамжийн материал | 75,545,536.76 | 71,241,254.28 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,251,100.00 | 371,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,807,424.20 | 2,696,368.72 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 71,076,512.56 | 68,173,385.56 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **711,368,616.87** | **713,004,254.78** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **711,368,616.87** | **713,004,254.78** |
| 392 | **Биет хөрөнгө** | **662,058,616.87** | **662,907,254.78** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 626,415,173.00 | 626,415,173.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,931,606.04 | -32,710,090.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 48,453,600.00 | 52,373,650.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,031,181.77 | -15,311,351.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,022,383.00 | 21,199,919.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,623,543.26 | -5,643,811.72 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 25,125,816.00 | 22,425,816.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,986,244.06 | -5,842,049.33 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **49,310,000.00** | **50,097,000.00** |
| 39301 | Програм хангамж | 787,000.00 | 787,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,310,000.00 | 49,310,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН I** | **790,313,953.63** | **784,245,509.06** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **788,605,630.63** | **784,245,509.06** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 788,605,630.63 | 784,245,509.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 575,706,037.00 | 575,706,037.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 575,706,037.00 | 575,706,037.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 195,692,479.95 | 191,332,358.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 195,692,479.95 | 195,692,479.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -4,360,121.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 17,207,113.68 | 17,207,113.68 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **790,313,953.63** | **784,245,509.06** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **715,066,210.20** | **484,657,885.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **673,204,810.20** | **441,105,919.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 254,163,310.20 | 24,824,319.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 254,163,310.20 | 24,824,319.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 254,163,310.20 | 24,824,319.50 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 419,041,500.00 | 416,281,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 419,041,500.00 | 416,281,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **41,861,400.00** | **43,551,966.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,930,000.00 | 2,115,166.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 1,418,166.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 280,000.00 | 697,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,931,400.00 | 41,436,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,931,400.00 | 41,436,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **456,813,683.87** | **486,403,787.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **456,813,683.87** | **486,403,787.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 426,669,811.42 | 479,587,316.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 278,135,144.90 | 336,352,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 237,711,058.90 | 254,140,554.00 |
| 210102 | Нэмэгдэл | 21,662,600.00 | 52,235,397.00 |
| 210104 | Урамшуулал | 18,761,486.00 | 29,976,393.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,110,108.71 | 43,311,034.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,097,812.79 | 30,019,621.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,482,357.89 | 3,371,838.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,013,683.30 | 2,697,250.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 501,381.59 | 656,556.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,014,873.14 | 6,565,767.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,349,156.94 | 36,739,912.28 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,167,774.94 | 3,326,103.14 |
| 210302 | Түлш, халаалт | 26,712,384.00 | 30,648,341.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,468,998.00 | 2,765,467.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,073,780.60 | 14,917,913.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,985,450.00 | 1,725,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 349,940.00 | 360,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 253,500.00 | 214,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 79,000.00 | 169,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 729,200.00 | 766,086.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,910,600.00 | 5,278,650.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,766,090.60 | 6,404,077.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,660,899.40 | 12,500,659.48 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,062,550.00 | 1,671,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,598,349.40 | 10,076,959.48 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 752,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,441,700.00 | 6,272,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,441,700.00 | 6,272,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 120,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 120,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 806,500.00 | 1,910,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 506,500.00 | 1,370,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 540,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,092,520.87 | 27,462,753.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,477,558.40 | 1,366,442.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,555,100.00 | 2,853,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,059,862.47 | 23,242,411.59 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 30,143,872.45 | 6,816,470.59 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 460,000.00 | 355,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 460,000.00 | 355,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,309,543.06 | 1,024,187.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,309,543.06 | 1,024,187.72 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 28,374,329.39 | 5,437,282.87 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,374,329.39 | 5,437,282.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **258,252,526.33** | **-1,745,901.57** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 2,614,220.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,614,220.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -2,614,220.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН** | **258,252,526.33** | **-4,360,121.57** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 575,706,037.00 | 17,207,113.68 | -42,746,590.39 | 550,166,560.29 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **575,706,037.00** | **17,207,113.68** | **-42,746,590.39** | 550,166,560.29 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -18,105,132.99 | -18,105,132.99 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **575,706,037.00** | **17,207,113.68** | **195,692,479.95** | 788,605,630.63 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **575,706,037.00** | **17,207,113.68** | **195,692,479.95** | 788,605,630.63 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **575,706,037.00** | **17,207,113.68** | **195,692,479.95** | 788,605,630.63 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,360,121.57 | -4,360,121.57 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **575,706,037.00** | **17,207,113.68** | **191,332,358.38** | 784,245,509.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 457,718,400.00 | 451,256,929.41 | 6,461,470.59 | 98.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 457,718,400.00 | 451,256,929.41 | 6,461,470.59 | 98.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 457,718,400.00 | 451,256,929.41 | 6,461,470.59 | 98.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 337,842,400.00 | 336,352,344.00 | 1,490,056.00 | 99.6 |
| 210101 | Үндсэн цалин | 243,157,800.00 | 254,140,554.00 | -10,982,754.00 | 104.5 |
| 210102 | Нэмэгдэл | 77,352,100.00 | 52,235,397.00 | 25,116,703.00 | 67.5 |
| 210104 | Урамшуулал | 17,332,500.00 | 29,976,393.00 | -12,643,893.00 | 172.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,608,700.00 | 45,019,357.13 | 589,342.87 | 98.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,095,000.00 | 31,727,944.73 | 367,055.27 | 98.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,378,400.00 | 3,371,838.66 | 6,561.34 | 99.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,702,700.00 | 2,697,250.21 | 5,449.79 | 99.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 675,700.00 | 656,556.41 | 19,143.59 | 97.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,756,900.00 | 6,565,767.12 | 191,132.88 | 97.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,164,100.00 | 36,139,912.28 | 1,024,187.72 | 97.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,500,000.00 | 3,326,103.14 | 173,896.86 | 95.0 |
| 210302 | Түлш, халаалт | 30,164,100.00 | 30,048,341.68 | 115,758.32 | 99.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 2,765,467.46 | 734,532.54 | 79.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,754,900.00 | 4,562,370.00 | 192,530.00 | 96.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 250,000.00 | 250,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 250,000.00 | 214,500.00 | 35,500.00 | 85.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 208,300.00 | 202,500.00 | 5,800.00 | 97.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 554,320.00 | 145,680.00 | 79.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,046,600.00 | 3,041,050.00 | 5,550.00 | 99.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,189,000.00 | 12,343,446.00 | 2,845,554.00 | 81.3 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 483,300.00 | 483,300.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 13,872,400.00 | 11,026,846.00 | 2,845,554.00 | 79.5 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 833,300.00 | 833,300.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,272,700.00 | 11,272,700.00 | 0.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,000,000.00 | 7,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,272,700.00 | 4,272,700.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,055,600.00 | 1,800,000.00 | 255,600.00 | 87.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,515,600.00 | 1,260,000.00 | 255,600.00 | 83.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3711000.00 | 3646800.00 | 64,200.00 | 98.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 377,700.00 | 313,500.00 | 64,200.00 | 83.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,333,300.00 | 3,333,300.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 457,718,400.00 | 451,256,929.41 | 6,461,470.59 | 98.6 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 416,281,600.00 | 410,844,317.13 | 5,437,282.87 | 98.7 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 416,281,600.00 | 410,844,317.13 | 5,437,282.87 | 98.7 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 41,436,800.00 | 40,412,612.28 | 1,024,187.72 | 97.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 41,436,800.00 | 40,412,612.28 | 1,024,187.72 | 97.5 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.0 | 01.0 | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.0 | 01.0 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 14.0 | 14.0 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.0 | 13.0 | 0.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 14.0 | 14.0 | 0.00 | 100.0 |

### 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,765,166.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,765,166.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,410,166.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,368,166.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 90,000.00 |

| | | |
|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 418,166.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 992000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 992,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 355000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 355,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 355,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2115166.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,115,166.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,418,166.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3.347,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бизкон-Аудит ХХК-ийн аудитор Д.Эрдэнэжаргал, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон-аудит ХХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын Ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн .

Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон аудит ХХК Хөвсгөл аймаг дахь салбарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулж буй Мөрөн сумын Засаг даргын харъяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Мөрөн сумын Арван нэгдүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн 2020 оны 2 дугаар сарын 25 -ны өдрийн А/05 тушаалаар 3 хүний бүрэлдхүүнтэй томилсон байна. Тайлант онд 4 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 456.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.1 сая төгрөгөөр буюу 0.77 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2.6 | 0.0 | - 2.6 |
| Бараа материал | 76.3 | 71.2 | - 5.1 |
| Үндсэн хөрөнгө | 711.4 | 713.0 | 1.6 |
| **Нийт хөрөнгө** | **790.3** | **784.2** | **- 6.1** |
| Өр төлбөр | 1.7 | 0 | -1.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 575.7 | 575.7 | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 195.7 | 191.3 | - 4.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 17.2 | 17.2 | 0,0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **790.3** | **784.2** | **- 6.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл 71.2 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр буурсан нь Ковид-19 цар тахал дэлхий нийтэд тархсантай хичээл сургалтын үйл ажиллагаа тогтмол явуулаагүйгээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 2.6 сая төгрөгийг хүлээн авч авлага буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 713.0 сая төгрөг болж, 1.6 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 4.2 сая төгрөг, урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авалтаар 7.0 сая төгрөг, дахин үнэлгээний үнийн зөрүүгээр 16.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 20 -ны 109 дүгээр тогтоол , Мөрөн сумын ИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 29 -ний " Хөрөнгө актлах " тухай 39 дүгээр тогтоолоор 7.3 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж , тавилга эд хогшлыг акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 784.2 сая төгрөг болж 4.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас нөлөөлсөн байна.

Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 484.6 сая төгрөгөөр буюу 32.3 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 29.6 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон цалингийн нэмэгдэл 58.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 7.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн зардал 5.2 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 457.7 сая төгрөгөөр , нийт зарлагыг 451.2 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг Мөрөн сумын ИТХ-ын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн хуралдаанаар 512.4 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төсвийн жилд 2 удаа хасах тодотгол хийж, Мөрөн сумын ИТХ-ын 2020 оны 8- дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрээр 479.9 сая төгрөг, Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07 -ны өдрийн А/608 дугаар захирамжаар 22.2 сая төгрөг, нийт 54.7 сая төгрөгөөр хасах тодотгол хийж, 457.7 сая төгрөгөөр батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 41,436.8 сая төгрөг нийт 457.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 451,3 сая төгрөгийг зарцуулж, 6.4 сая төгрөгийг хэмнэж, 98.6 хувьтай байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 457.1 сая төгрөгийн төсөв баталснаас 416.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 41.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоор санхүүжүүлэхээр батлагдсан байна .

Хүснэгт 2 /сая.төг /

| № | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71801/81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө | 225.8 | 224.0 | 1.8 | 99.2% |
| 2 | 71801/81834 | Сургалтын хэвийн ажиллагааг хангах | 176.6 | 175.8 | 0.8 | 99.5% |
| 3 | 71801/80109 | ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 41.4 | 40.4 | 1.0 | 97.5% |
| 4 | 71801/81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 13.9 | 11.0 | 2.9 | 79.5% |
| | | Нийт | 457.7 | 451,2 | 6.5 | 98.6 % |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47. 2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 3-р сарын 11 ний өдрийн А/33 тоот захирамжаар 2020 онд нэмэлт данснаас татан төвлөрүүлж, авлага үүсгэсэн 2,6 сая төгрөгийг буцаан олгосон, тендерийн орлого 0.014 сая төгрөг, мөн БСУГ-ын даргын 2021 оны 09 сарын 15 – ны өдрийн А/40 тоот тушаалаар ариутгалын зардал 0.2 сая төгрөг, Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 -р сарын 03-ны өдрийн А/145 тоот тушаалаар ”Эрүүл мэндийг дэмжигч “ байгууллагын шагнал 0,2 сая төгрөг, Мөрөн сумын дархлаажуулалтын хоолны зардал 0.2 сая төгрөг, постын хоол хүргэлтийн зардал 0.4 сая төгрөг, мөн Аймгийн Засаг даргын 2021 оны 8-р сарын 27 -ны өдрийн А/390 тоот захирамжаар ариутгал халдваргүйтлийн зардалд 1.0 сая төгрөг хувиарлагдан ирснийг эрх нээлгэн зарцуулсан байна..

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын дагуу хэмнэлт тооцоход цалин, нийгмийн даатгалын зардлаас бусад зардал болох 76.3 сая төгрөгөөс 7.6 сая төгрөг хэмнэхээс 6.4 сая төгрөгийг хэмнэсэн байх тул албан шаардлагаөгөх шаардлагагүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар батлагдсан " Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаануудыг гаргуулан авлаа

### 3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 10 төрлийн 504.9 сая төгрөгийн мэдээллийн хуулийн хугацаанд байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний мэдээний шийдвэрийн хуулбарыг оруулаагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1, 8.5, 8.6 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 16 ны 129 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг мөрдөн, нээлттэй тендер 64.8 сая төгрөг, Шууд худалдан авалтаар 15.0 сая төгрөг, нийт 80.7 сая төгрөгийн хүнс, бараа материал, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд , хэрэгжилтийн тайлан мэдээ хуулийн хугацаанд гарган , цахим системд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тус цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 500.0 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 784.2 сая төгрөг ба 284.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 284.2 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэн бөгөөд 284.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулага

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналд санхүүгийн залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үний дүн бүхий орлого , зарлагын гүйлгээний мэдээний шийдвэрийн хуулбарыг оруулаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого , зарлагын гүйлгээний мэдээний шийдвэрийн хуулбарыг хавсаргаж хэвшүүлэхийг зөвлөж байна.

2. **Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт

Тус цэцэрлэг нь улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 500.0 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 784.2 сая төгрөг ба 284.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Зөвлөмж өгөх

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж шинэчилж бүртгүүлэхийг зөвлаж байна..

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван нэгдүгээр цэцэрлэг | 2 | 284.2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 284.2 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН: ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /А.ЭРДЭНЭБААТАР/

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР: /Э.БАТ-ЭРДЭНЭ/

Огноо:

АХЛАХ АУДИТОР /Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН

АХЛАХ АУДИТОР /Ч.МӨНХБАЯР/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК- ныТ АУДИТОР /Д.ЭРДЭНЭЖАРГАЛ/

Огноо